



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК**

**ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ  
БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт  
/гэрээний дугаар: ЭТТ/202001334**

**Улаанбаатар хот  
2020**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“Эрдэнэс-Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хүнсний материалыг** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг 10 минутанд нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**“Эрдэнэс Тавантолгой” ХК**  
**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,**  
**1 дүгээр хороо, Жигжиджав-8,**  
**Финанс төв, 5 давхар 503 тоот,**  
**Утас: 75055555 дотуур утас-506**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |                                                         |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|---------------------------------------------------------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.                                                                                                                                                                                                          |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|                                                         | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|                                                         | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]                                                                          |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.                                                                                                                                                                                                                                                                       |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.                                                                                                                                                                                                                                               |
|                                                         | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.





Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн гэрчилгээний хуулбар,</li> <li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт /тендер зарласан өдрөөс хойших байдлаар/</li> <li>• Татварын албанд тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх /тендер нээсэн өдрийн байдлаар <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим сайтнаас татаж үзнэ. Хэрэв өртэй байвал тендерээс татгалзах үндэслэл болно/</li> <li>• Сүүлийн 1 жилийн буюу 2019 оны жилийн эцсийн аудитын дүгнэлтээр баталгаажсан санхүүгийн тайлан ирүүлэх,</li> <li>• Сүүлийн 2 жилийн буюу 2018, 2019 оны аль нэг жилд техникийн тодорхойлолтод заасан бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа материал нийлүүлж байсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл бүрэн чанартай нийлүүлж байсныг нотлох өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт зэргийн аль нэгийг хавсаргаж ирүүлнэ,</li> </ul> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлбэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх.</li> <li>• Тендерт санал болгосон хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх.</li> <li>• Банк, татвар, шүүхийн эрх бүхий байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлэх,</li> <li>• Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа тухай албан бичиг ирүүлэх,</li> <li>• Техникийн тодорхойлолтод заасан барааны “Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт” ирүүлэх.</li> </ul>
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар <b>2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг 00</b> минутаас өмнө хүлээн авна.
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар <b>2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг 10</b> минутад цахим системээр нээнэ. Нээлтэд биеэр ирэх шаардлагагүй бөгөөд нээлт болсон даруй тендер шалгаруулалтын үр дүн хэсгээс нээлтийн мэдээлэлтэй танилцах боломжтой.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр /сэлбэг, барааны дугаар/	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Техникийн тодорхойлолт
1	Шилтэй кофе Jacobs Monarchi нэрийг шилтэй кофе/190гр/ дүйцэх	ширхэг	300	Хурал, уулзалтуудын хэрэгцээнд	
2	Дүрдэг цай Ahmed нэрийн дүрдэг цай /100ширхэгтэй/ дүйцэх	хайрцаг	100		
3	Ногоон цай /100 ширхэгтэй/ дүйцэх	хайрцаг	100		
4	Зөөлөн чихэр /Алёнка, Коровка нэрийн чихрүүдтэй дүйцэх /	кг	50		
5	Хатуу чихэр /Wawel, Бусмлылапка, слива нэрийн чихэртэй дүйцэх/	кг	50		
6	Лого бүхий Алтанговь шоколад дүйцэх	кг	150		Алтанговь үйлдвэрийн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн логотой шоколад
7	Чанадаг кофе /300-500гр/ дүйцэх	ширхэг	100		

8	Кофены сүү Массофее нэрийн сайн уусдаг сүү /450гр/ дүйцэх	ширхэг	672	
9	Цагаан ёотон/1кг/ дүйцэх	хайрцаг	500	
10	Бор ёотон/1кг/ дүйцэх	хайрцаг	200	
11	Жигнэмэг /Любятово-315гр/ дүйцэх	ширхэг	300	
12	Жигнэмэг (Чокочипс-12ш) дүйцэх	хайрцаг	300	
13	Кей кофе Найруулдаг 70гр Special blend 1/12 (1972) дүйцэх	ширхэг	310	

Захиалагчийн бараа материал захиалан авах дээд хэмжээг заасан бөгөөд тухайн бараа материалыг захиалан авах тоо ширхэг нь компанийн хэрэгцээ шаардлагад үндэслэн багасч болно. Захиалагч бараа материалыг хүснэгтэд заасан дээд хэмжээгээр хүлээн авах үүрэг хүлээхгүй.

- 2. Баглаа, боодол:** Олон улсын болон Монгол улсад мөрлөгддөг стандартын дагуу зориулалтын сав, баглаа, лацтай боодолтой байх,
- 3. Бараа хүргэх газар:** “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж – 8, Финанс төв, Улаанбаатар-15160

4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	<i>Техникийн тодорхойлолтод заасан бараа бүтээгдхүүнийг захиалагчийн гаргасан захиалгын дагуу тухай бүрд нийлүүлнэ.</i>	<i>13 төрлийн бараа</i>	<i>Ширхэг, хайрцаг, кг</i>	<i>“Эрдэнэс-Таван толгой ХК”, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж – 8, Финанс төв, Улаанбаатар -15160 Өөрийн байранд, агуулах дээр</i>	<i>гүйцэт гэлээр</i>	<i>гүйцэт гэлээр</i>	



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.                                                                 |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.                                                              |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.                                                                                                                          |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.                                                                                                                                                                                                                                         |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.                                                                                                                                                                                                                                                           |
| 7. Төлбөр                                          | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.                                                                                                                                                                                                                        |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.                                                                                                                                                                                                                               |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.                                                                              |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.                                                                                                                                                                                         |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.                                                                                                                                                                                                      |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Захиалагчаас томилогдсон ажлын хэсгийн гишүүд бараа материал хүлээж авахдаа бараа материалын тоо ширхэг, хадгалалтын хугацаа, чанарын шаардлагыг техникийн тодорхойлолттой тулгаж хүлээн авна.
- 2. Төлбөр (ГЕН – 7)**
- 2.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Захиалагч гэрээ байгуулагдсанаас хойш хуваарийн дагуу нийлүүлэгдсэн хэрэглээнд үндэслэсэн гүйцэтгэлийг гарган захиалагч болон нийлүүлэгчийн хооронд үйлдсэн бараа хүлээлцсэн акт, нэхэмжлэх болон холбогдох бичиг баримтыг үндэслэн нийлүүлэгчийн тухайн сард нийлүүлсэн бараа материалын төлбөрийг нэхэмжлэх хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт нийлүүлэгч байгууллагын дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.
- Захиалагчийн тухайн бараа материалыг захиалан авах тоо ширхэг нь компанийн хэрэгцээ шаардлагад үндэслэн техникийн тодорхойлолтод заасан тоо ширхэгээс бага байх тохиолдолд захиалагч зөвхөн тухайн нийлүүлсэн бараа материалын үнийг нийлүүлэгч талд төлнө.
- Захиалагч техникийн тодорхойлолтод заасан дээд хэмжээгээр бараа материалыг хүлээн авах үүрэг хүлээхгүй.
- 3. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>**
- 5.1. Алданги оногдуулах хувь: **Хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн алданги оногдуулах хувь: 0,5 хувь**
- Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10 хувь**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;

\_\_\_\_\_

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]